

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

**“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН 2020 ОНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2021 оны 01 дүгээр
сарын 30

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2-т заасны дагуу <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд 2020 онд Төсвийн ерөнхийлөн захирагч /ТЕЗ/-ийн харьяа 49 байгууллага /үүнд: төсвийн 3, ДТГ 44, ТӨҮГ 1, төслийн 1 байгууллага/-ын цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Гадаад харилцааны яам, ДТГ-үүд 2020 онд хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг тухайд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллав.

Шилэн дансны хөтлөлтийг хянах ажлын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2020 оны бүх улирлын тайланг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, стандарт тогтоох журам”-ын 8.2-т заасан хугацаанд багтаан нийт 49 байгууллагын тайланг shilendans.gov.mn цахим хуудсанд заасан хугацаанд байршуулж ажилласан.

2. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, стандарт тогтоох журам”-ын 7.3.3-т заасны дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шилэн дансны цахим бүртгэлийг хөтлөхгүй болсон 4 байгууллагыг цахим системээс хасуулах, 2 байгууллагыг нэмж бүртгүүлэх хүсэлтийг Сангийн яаманд илгээж шийдвэрлүүлэв.

3. Шинээр бүртгүүлсэн ДТГ-үүдад Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандартыг тогтоох тухай журамд

заасан хугацааг баримтлан ажиллах, шилэн дансанд мэдээлэл байршуулах заавар, гарын авлагыг тус тус хүргүүлэв.


4. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу ГХЯ-ны “mfa.gov.mn” вэб сайтийн үйл ажиллагааны ил тод байдлын төрөлд яамны “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2020 оны 1, 2 дугаар улирлын тайлан”-г байршуулав.

5. Үндэсний аудитын газар /УАГ/-аас хийгдсэн “Нийцлийн аудит”-д Гадаад харилцааны сайдын буюу ТЕЗ-ийн багцийн байгууллагууд болон түүвэр судалгаагаар 13 ДТГ-үүд хамрагдаж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод хяналтыг “хэрэгжүүлж ажилласан” гэсэн үнэлгээ өгсөн. УАГ-ын аудитын шалгалтаар илэрсэн асуудлын бүртгэлийн маягтыг шалгалтанд хамрагдсан ДТГ-үүдад хүргүүлэв.

6. ЗГХЭГ-аас захирагааны байгууллагуудын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайландаа тус яамны “Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ” 98.6 хувийн хэрэгжилттэйгээр үнэлэгдэж, цаашид “... тогтоосон хугацааг баримтлан мэдээллээ байршуулахад бүх ТЕЗ нар анхаарах нь зүйтэй” зөвлөмжийг өгсний дагуу 2020 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2019 оны суурь түвшингөөс бууруулахгүй байх, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад анхаарах, цаг үеийн хүндрэлтэй байдалд нийцүүлэн төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай захиран зарцуулах, гарч болох аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэхэд анхаарч ажиллах талаар бүх ТЕЗ-ийн байгууллагуудад чиглэл хүргүүлэн ажиллав.


7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд улирал бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийж яамны удирдлагад танилцуулан ТНБД-аас өгсөн чиглэлийн дагуу “C”, “D” үнэлгээтэй ДТГ-үүдад хуулийн хэрэгжилтийг ханганд ажиллах талаар зөвлөмж, зааварчилгаа, чиглэлийг цахим шуудангаар хүргүүлэв.

Үүний үр дүнд ТЕЗ-ийн 49 байгууллагын дүнгээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 99.73 хувийн гүйцэтгэлтэй, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан мэдээллийн тоогоор 92.64 хувийн чанарын



үзүүлэлттэй гарч өмнөх онтай харьцуулан авч үзвэл 1.4 хувиар өссөн байна.


Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 6395 мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулан **92.64** хувийн чанарын үзүүлэлттэй гарч өмнөх оноос **8.12** хувиар өссөн байна.



Шилэн дансны цахим хуудсанд хуулинд заасан хугацаанд мэдээлэл хэрхэн байршуулсныг өмнөх онуутдтай харьцуулан үзүүлбэл:




Тайлангийн хугацаанд нийт 13 төрлийн 6899 /давхардсан тоогоор/ мэдээлэл цахим хуудсанд байршуулахаас 6395 мэдээлэл буюу 99.73 хувь байршуулж, үүнээс хуулийн хугацаанд 6395 буюу 92.7 хувь, хугацаа хоцорч 493 буюу 7.14 хувь, 11 буюу 0.2 хувь нь мэдээллээ байршуулаагүй байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулан үзвэл хугацаандаа байршуулсан байдал өмнөх оноос 8.18 хувиар өсөж, хугацаа хоцорсон үзүүлэлт 6.93 хувиар, мэдээлэл байршуулаагүй байдал өмнөх



оныхоос 1.48 хувиар тус тус буурсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 2020 оны хэрэгжилтийн байдлыг үнэлгээний эрэмбээр эзлэх хувийн жинг харуулбал:



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалын дагуу үнэлгээ хийхэд хуулийн хугацаанд байршуулсан байдлаар дүгнэхэд “А” буюу “үр дүнтэй 90-100” 36, “В”, “С” буюу тодорхой үр дүнд хүрсэн 60-89” 13 ДТГ, “С” үнэлгээтэй 3 ДТГ байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт үнэлгээний эрэмбээр өмнөх оноос “А” үнэлгээтэй 20.3 хувь 11 ДТГ-аар, “В” үнэлгээ 3.4 хувь буюу 2 ДТГ-аар тус тус өсч, “С” үнэлгээ 4 ДТГ буюу 8.79 хувиар буурч, 2020 онд D, F үнэлгээтэй нэгж байхгүй байна.

Дүгнэлт:

Гадаад харилцааны салбарын хэмжээний Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд 2020 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 99.73 хувийн биелэлттэй гарч өнгөрсөн онтой харьцуулахад хэрэгжилт 1.42 хувиар, шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуулийн хугацаандаа байршуулсан байдал өмнөх оныхоос 8.12 хувиар өсч, хугацаа хоцролт 6.93 хувиар, мэдээлэл байршуулаагүй байдал 0.16 хувиар тус тус буурчээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт үнэлгээний эрэмбээр өмнөх оноос “А” үнэлгээ 20.3 хувь буюу 11 ДТГ, “В” үнэлгээ 3.4 хувь буюу 2 ДТГ-аар тус тус нэмэгдэж, “С” үнэлгээ 4 ДТГ буюу 8.79 хувиар буурч, “D”, “F” үнэлгээтэй байгууллага байхгүй.

Иймд салбарын хэмжээнд Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт “хангалттай” биелсэн гэсэн үнэлгээтэй гарав.

Зөвлөмж:

1. 2021 онд шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулж буй байдалд ДТГ-уудын тэргүүн болон эрх бүхий ажилтан тогтмол хяналт тавьж, хуулийн хугацаандаа мэдээллээ бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувь хүргэх;

2. Шилэн дансны мэдээлэл оруулах санхүүгийн эрх бүхий албан тушаалтныг солигдох бүрт ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү эдийн засгийн хэлтсээс сургалт болон ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийн дагуу бэлтгэлийг сайтар хангуулж, зохих түвшинд мэргэшүүлж байх;

3. Сангийн яамны холбогдох газар, нэгжээс өгч буй цахим мэдээллээр уг дансыг хэрхэн хөтлөх тухай мэргэжил арга зүйн зөвлөгөө болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, стандарт тогтоох журам”-ын 3.2-т заасан хугацааг хэрхэн мөрдөж ажиллахтай холбогдуулан гаргасан зааврыг ДТГ-уудын тэргүүн болон эрх бүхий ажилтан үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах;